



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 77,390.9 (далан долоон сая гурван зуун ерэн мянга есөн зуу) мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүүд Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 4.2 дахь заалтыг ханган ажиллаж, дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2.-д “Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт, холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж, бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ” гэсэн заалтыг мөрдөж ажиллах;

2.2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны барилгын их засвар, тохижилтын ажлын гүйцэтгэлийг Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газарт актаар хүлээлгэн өгч, зардлыг капиталжуулж, хөрөнгийн өртгийг нэмэгдүүлэх;

2.3.Тус яамны нэр дээр бүртгэлтэй 4 байршил дахь 33,590.0 м.кв газрын эзэмших, ашиглах эрхийг үнэлж Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч, санхүүгийн тайлан, данс бүртгэлд тусгах;

2.4.Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолын 2 дугаар заалт болон уг тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

123006983
4-r huraldaan.docx

2.5.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал”-д дотоод аудит санхүүгийн хяналт шалгалтыг хийх гэж заасныг баримтлан ажиллах;

3.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 02 дугаар сарын 06-ны
өдрийн 5 дугаар тогтоолын хавсралт

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМАНД ХИЙСЭН
ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ АРИЛГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

№	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөгөөр)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын барилгын их засвар, тохижилтын ажлын гүйцэтгэлийг Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газарт актаар хүлээлгэн өгч, зардлыг капиталжуулж, хөрөнгийн өртгийг нэмэгдүүлээгүй	77,390,900.00	Төсвийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус мөрдөж ажиллах.
2	Яамны нэр дээр бүртгэлтэй боловч санхүүгийн тайланд бүртгэлгүй 4 байршил дахь 33,590.0 м.кв газар	33,590.0 м.кв газар	Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч, үнэлэн данс бүртгэлд тусгах;
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн		77,390,900.00 (далан долоон сая гурван зуун ерэн мянга есөн зуун төгрөг)	
		33,590.0 м.кв (гучин гурван мянга таван зуун ер) талбай бүхий газар	

.....00000.....